

## ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКНЫ ОРОЛЦООТОЙ 8 САЯ КАНАД ДОЛЛАРЫН САНХҮҮЖИЛТИЙН БАГЦ ЗАРЛАЛАА

---

### Хэвлэлийн Мэдээ

Нова Скошиа, Халифакс хот  
2019.10.15

**Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN)** (цаашид “**Эрдэнэ Ресурс**” эсвэл “**Компани**” гэх) нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (the “European Bank for Reconstruction and Development” буюу “EBRD”)-ны оролцоотой 8 сая канад долларын санхүүжилтийн багцыг танилцуулахад таатай байна. Эрдэнэ Ресурс нь EBRD-тэй хөрвөх нөхцөлтэй зээлийн гэрээ (“Зээлийн гэрээ”)-г баталгаажуулсан бөгөөд энэхүү зээлийн гэрээний хүрээнд Компани нь 5 сая америк долларын хөрвөх нөхцөлтэй зээлийг хүлээн авна. Үүнтэй зэрэгцэн, Эрдэнэ Ресурс нь 1.6 сая канад доллар хүртэл зуучлалгүй, хаалттай санхүүжилтийг хийхээр төлөвлөж байна. Санхүүжилтийн багц нь Компанийн Хөндий Алтны Төслийн (“Төсөл”) хараат бус эцсийн ТЭЗҮ (“FS”), анхны инженерчлэл загвар (“FEED”), хайгуул болон хөрөнгө оруулалтын зардлууд, ерөнхий ажлын капиталд зарцуулагдана.

#### Компани болон EBRD-ийн тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли: “Бид Монгол улс дахь хамгийн том гадаадын хөрөнгө оруулагчдын нэг EBRD-тэй хамтран ажиллах болсондоо таатай байна. Энэхүү хөрөнгө оруулалт нь Хөндий Алтны Төслийн эдийн засгийн боломж, мөн манай байгаль орчны болон нийгмийн хариуцлагын хөтөлбөрүүдийн стандартыг баталгаажуулсан явдал боллоо гэж үзэж байна. Санхүүжилтийг Хөндий Алтны Төслийг олборлолтын үе шатанд хүртэл хөгжүүлэх, хайгуул болон хөрөнгө оруулалтаар дамжуулан нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.”

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Байгалийн нөөцийн салбар хариуцсан дарга Эрик Рассмуссен (“Eric Rasmussen”): “EBRD нь Монгол улсын баруун өмнөд бүс дэх Эрдэнэ Ресурсийн Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийг дэмжин ажиллах болсонд баяртай байна. Эрдэнэ Ресурс нь энэхүү бүсэд олон жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай, хариуцлагатай хамт олон бөгөөд оролцогч талуудын эрх ашиг, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор нөөцийг хөгжүүлж байгаад бид талархаж байна” хэмээв.

#### EBRD-ийн Монгол дахь үйл ажиллагааны тухай

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“EBRD”) нь Монгол улс дахь хамгийн том гадаадын хөрөнгө оруулагчдын нэг юм. Өнөөг хүртэл EBRD нь Монгол улсын эдийн засгийн бүхий л салбарт 1.7 тэрбум еврогийн хөрөнгө оруулалт хийснээс дийлэнх нь хувийн хэвшилд оруулсан хөрөнгө оруулалт байна. EBRD нь Монгол улсын хувийн хэвшил болон дэд бүтцийн салбарын олон талт, тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэн ажилладаг.

## Хөрвөх боломжит зээлийн тухай

Зээлийн гэрээний хүрээнд EBRD нь компанийг 5.0 сая хүртэл америк доллараар санхүүжүүлнэ. Зээлийн урьдчилгаа санхүүжилт нь 2.5 сая ам.доллараар хийгдэж, удаах 2.5 сая ам.долларыг холбогдох нөхцөлүүдийг хангасны дүнд гэрээ хүчин төгөлдөр зурагдсанаас 45 хоногийн дотор Эрдэнэ Ресурсийн хүсэлтийн дагуу шилжүүлнэ. Жилийн 10%-ийн хүүтэй энэхүү зээлийг Компанийн сонголтоор капиталжуулж болох бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болсноос 36 сарын дараа төлөгдөх нөхцөлтэйгөөр хийгдсэн. Зээлийг дараах хоёр нөхцөлийн аль нэг нь бүрдсэний дараа 25%-ийн нэмэгдэлтэйгээр эргүүлэн төлж болно, үүнд: (1) NI 43-101 стандартын дагуу хийгдсэн эцсийн ТЭЗҮ-ийг бүртгүүлэх эсвэл Эрдэнэ Ресурсийн хяналтын багц солигдох (2) анхны санхүүжилтийн гүйлгээ хийгдсэнээс хойш 24 сар өнгөрсөн. Холбогдох нөхцөлүүдийг хангаснаар нэг, хоёр, гурван жилийн хугацаанд EBRD нь бүх зээл болон хэсэгчлэн хөрвүүлэх сонголтыг хийсэн тохиолдолд нэгж хувьцааг \$0.20 канад доллар буюу жил тус бүр 10%, 20% болон 30%-ийн нэмэгдэл үнэлгээтэйгээр компанийн Энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой. Компанийн төслүүдийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компанийн хувьцаа нь зээлийн баталгаа болно.

Зээлийн гэрээний ерөнхий нөхцөлүүдтэй энэхүү гэрээний нөхцөл нь адил байх бөгөөд Торонтогийн Хөрөнгийн Бирж болон бусад зохицуулагч байгууллага, гуравдагч этгээдийн зөвшөөрлийг авах шаардлагатай. EBRD болон Компани нь өөрөөр тохиролцоогүй бол зээлийн гэрээний анхны урьдчилгаа санхүүжилт 2019 оны 10 сарын 31-нд хийгдэхээр төлөвлөсөн.

## Хаалттай санхүүжилтийн тухай

Эрдэнэ Ресурс нь хаалттай санхүүжилтийн (the “Private Placement”) хүрээнд 8,000,000 ширхэг үнэт цаасны нэгж бүрийг (the “Units”) \$0.20 канад доллараар үнэлэн, нийт \$1,600,000 канад долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна. Үнэт цаасны нэгж бүр нь Компанийн нэг Энгийн хувьцаа болон энгийн хувьцаа худалдан авах эрх бүхий хагас (1/2) Варрант (“Warrant”)-аас бүрдэнэ. Варрант бүр нь санхүүжилт хаагдсанаас хойш 2 жилийн дотор нэг энгийн хувьцааг \$0.30 канад доллараар худалдан авах эрхийг олгоно.

Энэхүү хаалттай санхүүжилтийг Торонтогийн Хөрөнгийн Бирж болон бусад зохицуулагч байгууллагын зөвшөөрлийг авснаар 2019 оны 10 сарын 25-нд хаахаар төлөвлөж байна. Мөн хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан үнэт цаас нь санхүүжилт хаагдсанаас 4 сар, 1 хоногийн хугацаанд арилжихгүй байх (“Hold period”) үүрэг хүлээнэ.

## Хөндий Алтны Төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Компани нь 2018 оны 3-р улиралд Төслийн анхан шатны нөөцийн тооцооллыг тайлагнасан бөгөөд энэхүү тайланд 2.3 г/т алтны дундаж агуулга бүхий 10.1 сая тоннд (“Mt”) 751,000 унц алтны бодит нөөц (Хүснэгт 1- ээс харна уу) тогтоогдсон. 2019 оны 2-р сарын 4-нд танилцуулсан Анхан Шатны Эдийн Засгийн Тооцоололд (“АШЭЗТ”): Алтны үнийг \$1200/унц гэж төсөөлөхөд татварын дараах өнөөгийн үнэ цэн нь (5% хоргодуулалт) (“NPV5%”) 99 сая ам.доллар, дотоод өгөөжийн хувь (“IRR”) нь 56% байсан. Мөн тооцооллоор 8 жилийн турш 3.42

г/т дундаж алтны агуулга бүхий хүдрээс жилд дунджаар 51,200 унц алт үйлдвэрлэх боломжтой уурхайг төлөвлөсөн. Дээрх төлөвлөгөө нь төслийн үнэ цэнийн суурь бөгөөд цаашид хүдрийн биетийг тэлэх, нэмэлт нээлт хийх хэтийн төлөвтэй бүсүүд хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд багтдаг нь ирээдүйн өсөлтийн гол хүчин зүйл юм.

#### Хүснэгт 1 – Хөндий Алтны Төслийн нөөцийн мэдээлэл

Захын агуулга	Нөөцийн тодруулга	Хэмжээ (сая тонн)	Агуулга (Au г/т)	Алт (унц)
Санал болгосон(1)	Баттай	1.4	3.6	161,000
	Бодит	8.7	2.1	590,000
	<b>Баттай &amp; Бодит</b>	<b>10.1</b>	<b>2.3</b>	<b>751,000</b>
	Боломжит	5.2	1.8	291,000

(1) RPMGlobal нь Баян Хөндийн ил уурхайн нөөцийг 0.6 г/т, Алтан Нарын ил уурхайн нөөцийг 0.7 г/т харин ил уурхайгаас доош орших нөөцийн захын агуулгыг 1.4 г/т-оор тооцоолохыг зөвлөсөн.

Анхан шатны эдийн засгийн тооцоолол нь урьдчилсан таамаглал бөгөөд зарим тооцоолол нь боломжит нөөц дээр тулгуурласан болно. Боломжит нөөц нь урьдчилсан болон эцсийн техник, эдийн засгийн тооцоололд багтаахад геологи, эдийн засгийн хувьд эрсдэл өндөртэй. Ашигт малтмалын геологийн нөөцийг ашиглалтын нөөц гэж үзэхгүй бөгөөд эдийн засгийн ач холбогдолтой гэдгийг нь харуулах баталгаа байхгүй боловч эдийн засгийн үр ашигтайгаар олборлох боломжийн хэтийн төлөвтэй гэж ойлгоно. Анхан шатны эдийн засгийн тооцооллын тайлантай SEDAR дахь компанийн хуудасны “NI 43-101 Technical Report for the Preliminary Economic Assessment of the Khundii Gold Project” файлаар танилцана уу.

Петер Далтон (Peter Dalton, P.Geo) нь Компанийн ахлах геологич (Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд юм, тэрээр энэхүү хэвлэлийн мэдээний техникийн мэдээллийг хянан баталгаажуулсан болно.

### Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 4 хайгуулын, 2 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

### Урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг

EBRD нь одоогоор Компанийн Энгийн хувьцааг эзэмшдэггүй болно. (i) \$5.0 сая америк долларын санхүүжилтийг Компани хүлээн авч, (ii) зээлийн төлбөр төлөгдөх хугацаанд EBRD нь сонголтын дагуу нийт зээл болон тухайн хугацаа хүртэлх зээлийн хүүг нэгж бүрийн \$0.1995 канад долларын үнэлгээтэй хувьцаагаар хөрвүүлэх опционыг хэрэгжүүлснээр төсөөлбөл: EBRD нь Компанийн 33,077,694 Энгийн хувьцаа буюу Компанийн хөрвүүлэлтийн дараах нийт гаргасан болон арилжигдаж буй Энгийн хувьцааны 15%-ийг (Валютын ханшийг 2019 оны 10 сарын 11-ний Канадын төв банкны ханш буюу \$1 америк доллар = \$1.3198 канад доллартай тэнцэх ханшаар тооцсон) эзэмших эрхтэй болно. Дээр дурдсан хаалттай санхүүжилт энэхүү зээлийн нөхцөлд орохгүй.

EBRD нь энэхүү зээлийн гэрээг хөрөнгө оруулалтын зорилгоор байгуулсан болно. Зах зээлийн нөхцөл байдал болон бусад хүчин зүйлсийг харгалзан үзэж, EBRD нь Компанийн үнэт цаасыг авах, зарах, хадгалах боломжтой.

Урьдчилан сэргийлэх санамжийн хувийг Канадын үнэт цаасны зохицуулах хороонд бүртгүүлэх шаардлагатай бөгөөд энэхүү хэлцэлтэй холбоотой урьдчилан сэргийлэх санамжтай SEDAR, [www.sedar.com](http://www.sedar.com) дахь Компанийн цахим хуудсаас танилцах боломжтой. Мөн +976 11 317 974 дугаарт Цэрэнрааш овогтой Хангайтай холбогдон хүлээн авах боломжтой. EBRD-ийн төв оффис нь ИБУИНВУ-ын Лондон хот, EC2A 2JN, One Exchange Square-д байрладаг.

## Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

## Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>